

## МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН

### УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр  
Хурал хуралдсан газар: Монголын МСС-ийн “Туул” хурлын танхим

#### **ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ**

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар дор дурьдсан 4 асуудалтай танилцаж хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. Үндэсний “Аствишн” ХХК-тай байгуулсан Усны мэдээллийн сан хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлав.

Хоёрдугаар асуудал. АНУ-ын SITA корпорацтай байгуулсан Удирдлагын мэдээллийн SAP систем, холбогдох үйлчилгээ үзүүлэх гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлав.

Гуравдугаар асуудал. Азийн сантай байгуулсан Усны үнэ цэнэ, үйлчилгээний бодит өртгийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулж, хэвшил хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагааны дизайныг боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлав.

Дөрөвдүгээр асуудал. АНУ-ын “Хэйзен энд Соьер” компанитай байгуулах Лаг булшлах, боловсруулах техник, эдийн засгийн үндэслэл болон лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг батлав.